



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Г Эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Захиалагчийн урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлаар валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж тэсрэх материалын үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан “Пауэр Бласт” ХХК-тай байгуулсан ШО-16-17 тоот “Амиакийн шүү нийлүүлэх гэрээ”-ний 1 тонн тутам амиакийн шүүний үнийг 900,000 /НӨАТ шингэсэн/ төгрөгөөс ихгүй нөхцлөөр, ШО-16-18 тоот “Эмульсийн тэсрэх бодис нийлүүлэх гэрээ”-ний 1 тонн тутам эмульсийн тэсрэх бодисын үнийг 2,400,000 /НӨАТ шингэсэн/ төгрөгөөс ихгүй нөхцлөөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т зөвшөөрсүгэй.
2. Нийлүүлэгч компанитай шинэчилэн байгуулсан гэрээний үнийг гэрээний хугацаа дуусах хүртэлх хугацаанд хатуу мөрдөж ажиллах, шаардлагатай зохицуулалтыг гэрээнд оруулахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг 2016 оны 11 сарын 24-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Ц.ТҮМЭНЦОГТ